

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ОРШИЛ.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
2.1. Төслийн нэр.....	4
2.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	4
2.3. Төслийн байршил.....	4
2.4. Ордын нөөц.....	6
2.5. Ил уурхайн ажиллах горим.....	6
2.6. Ашиглалтын систем.....	6
2.7. Уурхайн үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмж.....	6
2.8. Ашиглалтын системийн сонголт, үндсэн үзүүлэлтүүд.....	6
2.9. Ил уурхайн хүрээнд олборлох боломжтой дайрганы нөөцийн тооцоо.....	7
2.10. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим.....	7
2.11. Уурхайн хүчин чадал.....	7
2.12. Уурхайн ажиллах горим.....	7
2.13. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө.....	7
2.14. Өрөмдлөг тэсэлгээний ажил.....	8
2.15. Хүний нөөц.....	8
2.16. Дэд бүтэц.....	8
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	9
БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ..	12
БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	18
6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.....	19
6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	21
6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө.....	24
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ	25
ДҮГНЭЛТ	26
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	27

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	4
Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол.....	4
Хүснэгт 3. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт	6
Хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын технологийн схем	6
Хүснэгт 5. Ил уурхайгаар олборлох боломжтой барилгын чулууны нөөцийн тооцоо	7
Хүснэгт 6. Уулын ажлын календарьчилсан төлөвлөлт.....	8
Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	16
Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	23
Хүснэгт 13. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө	24
Хүснэгт 14. 2025 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал.....	25

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. “Баян ам” нэртэй дайрганы ордын байршлын зураг	5
Зураг 2. “Баян ам” нэртэй дайрганы ордын байршлын зураг	5

БҮЛЭГ 1. ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Баян ам” нэртэй дайрганы ордыг ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 1-р хорооны нутагт орших “Баян ам” нэртэй 27.3 га талбай бүхий 15/R006 дугаартай тусгай зөвшөөрлийг Нийслэлийн Засаг даргын 2015 оны 04-р сарын 14-ний өдрийн шийдвэрээр 2911003058 дугаарын гэрчилгээтэй “Амьдралын илч” ХХК-д олгосон ба хайгуулын ажил явуулах батлагдсан төлөвлөгөөний дагуу тус компани эрэл-хайгуулын ажлыг 2017 онд гүйцэтгэжээ.

БОМТ-ний тайлан боловсруулах аргачлал:

Тус төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Амвдралын илч” ХХК
2	Улсын бүртгэлийн дугаар		2911003058
3	Уурхайн нэр		“Баян ам” нэртэй дайрганы орд ашиглах төсөл
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Улаанбаатар хот
5		Сум/Дүүрэг	Налайх
6	Ашигт малтмалын төрөл		Дайрга
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		18/M011
8	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар хот
9		Сум/Дүүрэг	Налайх
10		Баг/Хороо	1-р хороо
11	Захирлын хаяг	Нэр	Захирал Ж.Амьдралхүү
12		Гар утас	976-96006580

2.1. Төслийн нэр

“Баян ам” нэртэй дайрганы ордыг ашиглах төсөл

2.2. Төсөл хэрэгжүүлэгч


“Амьдралын илч” ХХК

2.3. Төслийн байршил

Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 36 км, Налайх дүүргээс зүүн хойш 4 км зайд байрладаг. Засаг захиргааны хувьд Налайх дүүргийн 1-р хорооны нутагт харьяалагдана. Нийт 27.3 га талбайтай.

Хүснэгт 2. Талбайн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	18	41.7	47	47	45.76
2	107	19	5.9	47	47	45.76
3	107	19	9	47	47	38
4	107	19	9	47	47	29.44



Зураг 1. “Баян ам” нэртэй дайрганы ордын байршлын зураг



Зураг 2. “Баян ам” нэртэй дайрганы ордын байршлын зураг

2.4. Ордын нөөц

“Баян ам” нэртэй дайрганы ордод явуулсан хайгуулын дүнгээр батлагдсан нөөцийг дараах хүснэгтэд харуулав. Түгээмэл тархацтай ашигт малтмал дайрганы олборлолтыг ил уурхайн хэлбэрээр 10 жилийн хугацаанд ашиглахаар тооцсон байна.

Хүснэгт 3. Ордын геологийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

№	Нөөцийн блокийн дугаар	Дайрганы огтлолын дундаж талбай, мян.м ²	Зүсэлт хоорондын дундаж зай, м	Дайрганы нөөц, мян.м ³	Дайрганы нөөц, мян.тн	Блокийн талбай мян.м ²	Хөрсний зузаан. м	Хөрсний эзлэхүүн, мян.м ³
1	В-I	6.32	223.5	1413.38	3816.14	43.94	2.28	100.2
2	В-II	7.5	195.93	1469.7	3968.2	39.29	2.45	96.27
	Нийт В	13.8	419.43	2883.09	7784.34	83.24	2.36	196.46
3	С-1	2.73	212.22	578.41	1561.7	20.49	2.2	45.09
4	С-2	3.14	194.15	609.25	1644.99	19.07	2.5	47.67
	Нийт С	5.86	406.37	1187.7	3206.69	39.56	2.35	92.76
	Бүгд В+С	19.69	825.79	4070.75	10991.02	122.8	2.35	289.2

2.5. Ил уурхайн ажиллах горим

Уурхай нь хоногийн 1 ээлжээр ажилладаг ба ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байдаг. Уурхайн ажиллах хоног улирлын чанартай тул ажилчид долоо хоногт 1 өдөр амрах байдлаар ажилладаг байна.

2.6. Ашиглалтын систем

“Баян ам” ордын ил уурхайд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ажилладаг.

Хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын технологийн схем

Ашиглалтын арга	Ашиглалтын систем	Үндсэн ажил	Технологийн процессууд
Ил уурхай	Тээвэртэй, гадаад овоолготой	Хөрс хуулалт	Ухаж ачих
			Тээвэрлэх
			Овоолох
		Дайрга олборлолт	Ухаж ачих
			Тээвэрлэх
			Овоолох

2.7. Уурхайн үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмж

Ил уурхайн уулын ажилд 1 ш Cat-320 экскаватор, 2 ш Howo автосамосвал, 1 ш Luigong ZL50G утгуурт ачигч, 1 ш Shantui SD13 бульдозер тус тус ажиллаж байна.

2.8. Ашиглалтын системийн сонголт, үндсэн үзүүлэлтүүд

Баян ам дайрганы орд нь уул-техникийн ямар нэг хүндрэлгүй, ил аргаар олборлох боломжтой тул ажлыг экскаватор болон автосамосвал хосолсон, тээвэртэй ашиглалтын системээр үйл ажиллагаа явуулна.

2.9. Ил уурхайн хүрээнд олборлох боломжтой дайрганы нөөцийн тооцоо

Баян ам дайрганы ордын батлагдсан геологийн нөөц В+С зэрэглэлээр 4,070.75 мян.м³ үүнээс В зэрэглэлээр 2,883.08 мян.м³, С зэрэглэлээр 1,187.66 мян.м³ байна. Үүнээс ордын В нөөцийг бүрэн олборлох ба зайлшгүй байдлаар С нөөц өртөнө.

Хүснэгт 5. Ил уурхайгаар олборлох боломжтой нөөцийн тооцоо

Блоккийн дугаар	Ил уурхайн хүрээнд олборлогдох нөөц		Ил уурхайн хүрээний гадна үлдэх нөөц	
	мян.м ³	мян.тн	мян.м ³	мян.тн
В	2,659.06	7,179.46	138.91	375.04
С	193.77	523.19	993.89	2683.49
(В+С)	2,852.83	7,702.64	1,132.79	3,058.5

2.10. Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ орон нутгийн зам, барилга бүтээн байгуулалтад ашиглахаар тусгасан. Иймд тус уурхайн хүчин чадал, дайрганы эрэлт хэрэгцээ зэргийг үндэслэн уурхайн хүчин чадлыг жилд 150 мян.м³ байхаар тооцооллоо. Цаашид орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хүчин чадлыг нэмэх боломжтой.

2.11. Уурхайн хүчин чадал

Ил уурхайн нийт ашиглалтын хугацааг дараах байдлаар тодорхойлов.

$$T_a = \frac{Q_a}{A_{ж}} = \frac{2810}{150} = 18.73 \approx 19 \text{ жил}$$

Үүнд:

Q_a – Үйлдвэрлэлийн нөөц, мян.м³

$A_{ж}$ - Уурхайн жилийн дундаж хүчин чадал, мян.м³

2.12. Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилд 214 хоног ажиллах бөгөөд тухайн ажиллах хугацаан дахь Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын нөхцлөөс хамаарсан түр зогсолт болон долоо хоногийн нэг өдөр амрах зэрэг хоногуудыг тооцон уурхайг бодитоор 180 хоног ажиллана гэж төсөлд тусгалаа.

2.13. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Уулын ажлын төлөвлөлт, уурхайн календарь төлөвлөлтийг GeoviaSuprac программ дээр хийж тус тус гүйцэтгэсэн.

Энэхүү тодотгол хэрэгжих эхний жилийг 2024 оноос эхлэн явуулахаар төлөвлөсөн.

Жилийн 150 мян.м³ хүчин чадалтайгаар 19 жил ашиглах бөгөөд 2,810.03 мян.м³ дайрга олборлож 517.4 мян.м³ хөр хуулалтын ажил хийхээр байна.

Хүснэгт 6. Уулын ажлын календарьчилсан төлөвлөлт

Ашиглалтын жил	Олборлох барилгын чулуу		Хаягдал		Үйлдвэрлэлийн нөөц		Хөрс
	м³	тн	Хувь	м³	м³	тн	м³
1	150,000	405,000	1.5%	2,250	147,750	398,925	89806
2	150,000	405,000	1.5%	2,250	147,750	398,925	53657
3	150,000	405,000	1.5%	2,250	147,750	398,925	30659
4	150,000	405,000	1.5%	2,250	147,750	398,925	29794
5	150,000	405,000	1.5%	2,250	147,750	398,925	30321
6-10	750,000	2,025,000	1.5%	11,250	738,750	1,994,625	140085
11-19	1,352,831	3,652,644	1.5%	20,292	1,332,539	3,597,854	143100
Нийт	2,852,831	7,702,644	1.5%	42,792	2,810,039	7,587,104	517,422

2.14.Өрөмдлөг тэсэлгээний ажил

Уурхайд хөрс хуулах болон дайрга олборлох ажилд БНХАУ-д үйлдвэрлэсэн JK358H маркийн цахилгаан өрмийн машин 1ш ашиглахаар сонгосон байна.

Уурхайн доголын өндөр 5м, налуугийн өнцөг 60-900 байхаар тооцсон бөгөөд 1м цооног тэслэхэд 18.1-22.2 м³ уулын цул тэсэлнэ. Жилд тэслэх уулын цулын нийт хэмжээ нь 150-260.4 мян.м³ ба 12 удаагийн тэсэлгээ хийгдэхээр тооцоолсон ба АНФО төрлийн тэсрэх бодис (Аммонийн нитрат ба дизель түлшний хольц), тэсрэх хэрэглээнд Нонель системийг хэрэглэнэ.

2.15.Хүний нөөц

Уурхайн орон тоог тооцож уурхайд нийтдээ 23 хүн ажиллана.

2.16.Дэд бүтэц

Тус төслийн бүтээн байгуулалтын ажил 2019 оноос эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар

- Харуулын байр
- Цахилгааны дэд станц
- Хамгаалалтын хашлага гэх мэтийг барьж байгуулан ашиглаж байна.

Эдгээр барилга байгууламж нь цаашид уурхайн үйл ажиллагааг хэвийн явуулахад хангалтгүй бөгөөд нэмэлтээр барилга байгууламжийг барихаар төсөлд тусгалаа.

Цахилгаан хангамж:

Цахилгаан хангамжийн хувьд Зүүн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдож цахилгаан эрчим хүчээр хангагддаг.

Усан хангамж:

Налайх дүүргийн нийтийн худгаас зөөврөөр ахуйн хэрэглээний усыг хангаж ирсэн.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Физик газарзүй:

Тус уурхай байрлах Налайхын хотгор нь газарзүйн хувьд Хэнтийн уулархаг нутагт хамаарах бөгөөд Хэнтийн гол ба салбар уулсын бэлийн бэсрэг уулс, ухаа толгодоор хүрээлэгдэнэ. Налайхын хотгор нь 200 км² талбайтай, өргөргийн дагуу бага зэрэг сунаж, урт нь 17-20 км, өргөн нь 10-12 км, умард талаараа өндөр бус уул толгодоор Туул голоор тусгаарлагдах ба уртрагийн чиглэлтэй хэд хэдэн богино хөндий хоолойгоор хэрчигдэнэ. Хотгорын баруун хойт, баруун талаараа Баянзүрх, Богд уулын хаяа бэлийн уулс, өмнөд ба зүүн талаас нь Буурын даваа, Жанчивлангийн бэсрэг ухаа толгод хүрээлж үндсэндээ битүү хотос гэж болно. Хүрээлэх уулс нь ихээхэн хэрчигдэж бартаа ихтэйгээс гадна уулсын ар хажуу, гуу жалгаар ой мод, бут төгөл ургадаг. Хотгор гүдгэрийн үнэмлэхүй ба харьцах өндөр харилцан адилгүй. Толгодын үнэмлэхүй өндөр 1580-1750 м, хамгийн өндөр цэг нь дэлхийн усны хагалбар уулс болох Богдхан уул нь 2200 гаруй метр өндөрт өргөгдсөн. Төслийн талбай нь район далайн түвшнээс дээш 1480-1550 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан толгодын бэл тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгийн 11.50-22.70 (градус) байна.

Цаг агаар:

Налайх дүүрэг эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадасны хэмжээ бага температурын эрс хэлбэлзэлтэй, агаарын чийгшилт бага байдаг нь тус дүүргийн уур амьсгалын шинж юм. Өвлийн улирлын үргэлжлэх хугацаа 5-6 сар, цасан бүрхүүлийн дундаж зузаан 8 см. Хавартаа салхи ихтэй, агаар хуурай, хоногийн температурын хэлбэлзэл их, унасан цас эрт хайлж уурших тул голдуу шороон шуурга зонхилно. Зуны улирал богино, халуун хур бороо багатай байдаг хөрсний улирлын хөлдөлт нь 10 сарын сүүлч 11 сарын эхээр эхлэн 4 сар хүртэл үргэлжилнэ. 5, 6-р сараас эхлэн улирлын хөлдөлт гэсэж эхэлдэг. 7 сард гэсэглэн үе нь гадаргаас 0.5 м хүртэл гүнд 8-р сард 0.5-1.5 м, 9-р сард 2-3 м хүртэл гүнд тус тус тохиолдоно. Налайх дүүрэгтэй ойр орших Хүрэл тогоотын цаг уурын станцын хэмжилтээс үзэхэд агаарын температурын олон жилийн дундаж нь -1.8°C, хамгийн хүйтэн үе болох 1 р сарын олон жилийн дундаж утга нь -27.4°C, хамгийн бага үнэмлэхүй утга 47.20C байдаг. Агаарын температур нь хамгийн өндөр утгандаа 7 сард дундаж нь +17.1°C. Жилд унах хур тунадасны хэмжээ уулархаг газраа 207.3-369.8 мм-ийн хооронд хэлбэлзэх авч чухамдаа хотос хонхортоо үүнээс бага ажээ. Жилд унах хур тунадасны 70-80% нь зуны улиралд тухайлбал 7,8-р сард буудаг. Хэвтээ гадаргын 1 м² талбайд үйлчлэх цасны жин 50 кг/см². Агаарын чийгшилтийн сарын дундаж утга нь 50-70% хооронд хэлбэлзэх бөгөөд 60-65%-ийг дундаж утга гэж үзэж болох юм. Жилийн нийт өдрүүдийн 70% арчим нь салхитайд тооцогдоно. Салхины дундаж хурд өвөл 1.4 м/с, хавар 2.75 м/с, зун 2.92 м/с, намар 1.8 м/с. Үнэмлэхүй чийгшилтийн жилийн дундаж -4.5 м/г, харьцангуй чийгшилтийн дундаж -62%, VII сарын 13 цагийн харьцангуй чийгшил -59%, жилийн тунадас 447 мм, дулаан улирлынх 41.5 мм, нэг хоногт орох 72 мм, цасны хамгийн зузаан 5 см байдаг.

Усан орчин:

Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далбайн ай сав, Туул голын сав газарт тус тус багтана. Налайхын район усан сүлжээний хувьд муу, хотгорын нийт талбайн хэмжээнд ус багатай. Жижиг голуудын нэг болох Налайх гол Туул голд цутгадаг. Налайхын гол нь Баянбүрд уулын зүүн хормой дахь том биш гидролаххолит булгуудаас эх авч, хотгорын төв хэсгээр хойшоо чиглэн урсдаг. Голын голдрил нь 2-4 м өргөн, тунгалаг хүйтэн устай. Налайх дүүрэг нь Туул голын дунд хэсгийн дээд талын хэсэгт оршдог. Энэ хэсэг баруун гараас Тэрэлж, зүүн гараас Элстэй, Налайхын голууд цутгадаг. Налайх голын сав газрын баруун доод хэсэгт Бүс нуур байдаг. Элстэй, Налайхын гол нь ус судлалын байнгын хяналт, ажиглалтад хамрагддаггүй учраас судалгааны өгөгдөл мэдээлэл хомс юм. Налайх ба Элстийн гол нь Налайхын хотгорт Налайхын нүүрсний их уурхайн дээгүүр урсдаг. Ус зүйн хувьд Налайх голын нэг онцлог нь нүүрсний ордын доорх нь талаас газарт шургаж 4 орчим км газар тасарч, дахин ил гарч 2 орчим км урсаад дахин хөрсөнд шургаж тасардаг. Мөн энэ тасархайн доод хэсэгт Бүс нуур байдаг бөгөөд энэ нуур гүний тэжээлтэй нуур юм. Хэмжилтийн дүнгээр Налайх голын урсац гүнд шургахын өмнө $0.057 \text{ м}^3/\text{с}$ байсан бол ил гарсны дараа $0.032 \text{ м}^3/\text{с}$ болж буурснаас үзэхэд тэр алдагдсан 43% нь нуурын усыг газрын доогуур тэжээдэг байх магадлалтай юм. Яагаад гэвэл гол мөрний ус урсгалын дагуу нэмэгддэг зүй тогтолтой бөгөөд хэрэв урсац буурч байвал энэ хэсгийн газрын доорх усны төвшин голын усны төвшнөөс доогуур байгаагаас гол газрын доорх усаа тэжээх эсвэл ойролцоо орших нуурт цутгадаг. Бүс нуур нь хүхэрлэг шавартай тул нутгийн иргэд үе мөч, арьс, ядаргааны өвчнөө эмчлэхээр нуурын усанд орж, шаврыг нь эмчилгээнд хэрэглэдэг байсан байна. Нутгийн иргэдийн ярианаас үзвэл нуурын ус бохирдсон тул хүмүүс эмчилгээнд хэрэглэхээ больсон байна. Мөн энэ нуурын эргэн тойронд хужир, марзтай бэлчээр бий. Энэ бэлчээрт ойр хавийн малчид малаа хужирладаг.

Хөрс, ургамал:

Талбай орчимд хар хүрэн, хүрэн бор хөрс зонхилон тархжээ. Судалсан талбай нь ихэнх тал хангай газар болох тул хангайн хүрэн, хээрийн бор хөрс зонхилох ба хялганат хазаар, шивээ зэрэг бэлчээрийн ач холбогдолтой ургамлаар баян нутаг юм. Хааяа уулс, цав толгод тал газрын дагуу монголын ба дорнод монголын хэв шинж бүхий алаг хялганат хиаг өвс, элсэг алаг-өвс ба сөөгөн ширэнгэт, чулуусаг алаг хялганат өвс монгол тал хээрийн хэв шинж бүхий харгана, үетэн-хиаг хялганат хиаг зэрэг ургамлууд тархжээ.

Амьтан:

Налайх дүүрэг түүний эргэн тойрны уулсын ам хөндий, толгодын бэл хормойн хээр талд өвөгт тогоруу, зээрд шонхор, боролзой болжмор, монгол болжмор, адууч чогчоохой зэрэг шувууд элбэг тохиолддог ба сохор элээ, хон хэрээ, хар хэрээ, хээрийн бор шувуу, оронгийн бор шувуу зэрэг 9 зүйл жигүүртэн тэмдэглэгдсэнээс тус нутаг дэвсгэрт гэрийн тэжээмэл амьтад, хортон шавж, хот суурины шувууд зэрэг амьтад тохиолдож байна. Тус бүс нутгийн хэмжээнд ховордсон болон ховордож болзошгүй жигүүртэн шувуу, зэрлэг амьтад байдаг. Тухайлбал ооч ёл (VU), нөмрөг тас (LC), идлэг шонхор (VU), зээрд шонхор (LC), шар элэгт хөмрөг (NT), халиун буга (CR),

баданга хүдэр (EN), мануул мий (NT), саарал чоно (NT), хярс (NT), шар үнэг (NT), бух сугас (NT), шивэр хадран (NT) зэрэг болно. Ооч ёл, шар хөмрөг, хүдэр зэрэг нь Монгол улсын улаан номд орсон байна.

Нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Налайх дүүрэг нь Засаг захиргааны 8 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

Хоймортоо Майхан уулаа залж, Хатан тунамал Туул гол, Тэрэлжийн голоо зүмбэрлүүлэн, түүх домогт Чингис уул, Суварга хайрхнаа дээдлэн шүтэж, Зуун ламын агуй, Арьяабалын сүм хийд, Мэлхий хад, Бүс нуур, Элстэйн зуун мод бүхий үзэсгэлэнт сайхан Налайх нутаг өдгөө ч үйлдвэржилт эрчимтэй хөгжиж буй хот хэвээр байна.

Налайх дүүрэг нь Улаанбаатар хоттой төмөр зам болон засмал замаар холбогдсон, дэд бүтэц сайн хөгжсөн. Зүүн аймгуудыг холбосон хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай зам талбайн баруун хойно 0.5 км зайд дайран өнгөрдөг. Жилийн 4 улиралд “Баян ам”-ийн ордод автомашинаар зорчин очих боломжтой юм.

Сүүлийн жилүүдийн геологийн судалгаагаар тус дүүрэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой элс, хайрганы болон барилгын материалын ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, карьерын аж ахуйнууд үйл ажиллагаагаа явуулж байна. Засаг захиргааны 8 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг.

БҮЛЭГ 4. ТӨСЛИЙН ГОЛ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Амьдралын илч” ХХК нь 18/М011 тоот тусгай зөвшөөрөл бүхий 27.1 га талбайтай. “Баян ам” дайрганы ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны үед газрын хэвлий эвдэгдэх,
- Уурхайн үйл ажиллагаагаар газрын гадарга өөрчлөгдөх,
- Уурхайн үйл ажиллагааг ТЭЗҮ төлөвлөлтийн талаар явуулахгүй байх.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт үүсэх,
- Бутлуурын хэсэгт тоосжилт үүсэх,
- Уурхайн тэсэлгээ хийх үед дуу чимээний нөлөөлөл үүсэх,
- Тээврийн хэрэгслийн яндангаас үүсэх хорт хий утаа, тортог үүсэх,
- Хог хаягдлаас үүсэх орчны эвгүй үнэр үүсэх.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Технологийн болон унд ахуйн усыг гүний худгийн усаар хангана. Энэ тохиолдолд газрын гадаргын болон гүний усны нөөцөд тодорхой хэмжээний хомсдол үүсгэх болно.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Технологийн процесс, тоосжилтыг дарахад ашиглах болон ундны усыг гүний худгаас хангах учир гүний усны нөөцөд бага хэмжээний өөрчлөлт оруулна.
- Түлш шатахуун, шатах тослох материалууд, бохир ус алдагдсанаас үүдэн бага гүнд орших уст давхарга бохирдох.
- Газрын доорх усан орчин бохирдсон тохиолдолд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлнө.

Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс олон салаа зам үүсч хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх,
- Хөрсний шинж чанар техноген гаралтай хүчин зүйлүүдийн нөлөөгөөр элэгдэлд өртөж, хими-физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах,
- Тээвэрлэлтийн машин техникт үзлэг засвар хийх үед нефтийн бүтээгдэхүүн, шатах, тослох материал, хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулах.
- Хөрс хуулах, карьерын талбайгаар хөрс сулран ургамлын нөмрөг бүр мөсөн устаж үгүй болно,
- Ажилчдын суурингийн эргэн тойрон, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн улмаар тоног төхөөрөмжийг газрын гадарга дээр засварлах, тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөн зэргээс хөрс талхлагдан, ургамлын төрөл зүйл, ургалт доройтно.

- Олборлолтын үеийн шороо тоос орчны ургамалжилтанд нөлөөлж, ургалт удааширна.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл:

- Олборлолтын талбайд ямар нэгэн шавжийн бүлгэмдэл, хөхтөн амьтад байхгүй. Олборлолт хийж байгаа газарт болон хаягдал овоолох талбайд байршиж байгаа шавж идэштэн, мэрэгч амьтдын нүх оромж, орчинтойгоо устаж үгүйрнэ,
- Дуу шуугиан, машин техник болон хүний хөл хөдөлгөөн ихсэх зэргээс улбаалан, ан амьтад, шувууд үргэн дайжиж, тархалт байршилт нь өөрчлөгдөнө,
- Уурхайн ухсан нүх суваг, шуудуу руу мал амьтан уурхайн талбай руу унаж, бэртэх аюултай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:

- Уурхайн үйл ажиллагааны явцад техникийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүйгээс эсвэл гэнэтийн аюул осол гарснаас улбаалан ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай,
- Уурхайн ажлын үед ашиглаж буй техник, машин механизмаас дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн ам, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлнэ,
- Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлийн дуу чимээ, тоосжилт ихэссэнээр хүн ам болон ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлнэ.
- Уурхайд ажиллагсдыг хортой, хүнд нөхцөлд ажилладаг учир эрүүл мэндэд эрсдэл учрах аюултай.

БҮЛЭГ 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Амьдралын илч” ХХК-ийн “Баян ам” нэртэй дайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“Баян ам” нэртэй дайрганы ордыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан.

Энэхүү БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь тухайн төслөөс байгаль орчинд учруулах гол сөрөг нөлөөлөл болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлж түүнд шаардагдах хөрөнгө зардлыг тусгадаг.

“Амьдралын илч” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11-р сарын 01-ны дотор төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 20,379.0 мян.төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулин дээрх шаардлагын дагуу “Баян ам” нэртэй дайрганы ордын үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын гол зорилго нь “Баян ам” нэртэй дайрганы ордын үйл ажиллагааны бүхий л үе шатыг хамрах ба төслийн үйл ажиллагаанас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг болзошгүй гол нөлөөлөл болон цаашид учруулж болзошгүй эерэг болон сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

БҮЛЭГ 6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕМНЕТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж- их нэгж	Нэг- жийн зардал, төгрөг	Тоо хэм- жээ	Нийт зардал, төгрөг, / 2025 он /	Хэрэгжүү- лэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	-Ил уурхайн олборлолтын үед тоосжилт үүсэх, -Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, -Тэсэлгээний үед үүсэх тоосжилт.	Уурхайн тээвэрлэлтийн зам, уурхай орчимд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх	Уурхайн талбай, тээвэрлэлт-ийн зам	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 4585:2007. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 3384:1982. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, -MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, -MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга.
2		Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийх, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах, хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Тээврийн хэрэгсэл	-	50,000	4	200,000	Жил бүр	
2		Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийн төлбөрийг төлнө.	Тээврийн хэрэгсэл	-	-	-	200,000	Жил бүр	
3		Тэсэлгээг тодорхой хуваарийн дагуу хийх, тэсэлгээ хийх үеийн салхины хурд, чиглэлийг харгалзан үзэх, хүчтэй салхитай өдөр тэсэлгээний	Тээврийн хэрэгсэл	-	-	-	Дотоод төлөвлөлт- өөр	Жил бүр	

		ажил хийхгүй байх							
		Уурхай нь суурин газартай ойрхон байрладаг тул олборлолтын үед дуу чимээний нөлөөллийг аль болох бага хэмжээнд байлгах, шөнийн цагаар уурхайн үйл ажиллагааг явуулахгүй байх.	Уурхайн талбайд	-	-	-	-	Тогтмол	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	-Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс хөрс элэгдэл эвдрэлд өртөх, -Хог хаягдлаас үүдэн орчин бохирдох, -ШТМ асгарч газрын гадарга хөрсийг бохирдуулах.	Уурхайн талбайн эргэн тойронд уурхайн үйл ажиллагаа явагдаж байгааг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх, сайжруулах.	Уурхайн талбайд	-	-	-	2,000,000	Уурхайн үйл ажиллагааны үед	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага, - MNS 3310-91, Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох, - MNS 17.5.1.19-92, БОХ. Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавигдах шаардлага, - MNS4919:2000, “Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага”
2		Өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах, нөхөн сэргээлтэнд ашиглах.	Шимт хөрсний овоолго	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2025 онд	
3		Шимт хөрсний овоолгыг салхинд тархахаас сэргийлж хамгаалах, ургамалжуулах		-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	Жил бүр	
4		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавьж ажиллах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд цаг тухай бүрт нь саармагжуулах арга хэмжээ авах	ШТМ	-	-	-	-	Тухай бүрт	
5		Шатах тослох материалыг хадгалах зориулалтын сав байрлуулах, аюултай хог	ШТМ цуглуулах поошик	-	-	-	Дотоод төлөвлөлт-өөр	2025 онд	

		хаягдал дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх							
Усан орчин									
1	- Гүний худгийн усыг	Ахуйн бохир усыг ил задгай асгахгүй байх	Ахуйн бохир ус	-	-	-	-	Тухай бүрт	-Усны тухай хууль, -MNS 900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт.
2	ашигласнаар усны нөөц хомсдох,	Уурхайн талбайд гаргасан гүний худгийг бохирдохоос сэргийлж, хашаалж хамгаалах	Гүний худаг	-	-	-	1,000,000	2025 онд	
3	- Бохир усыг ил	Гүний худгийг тоолууржуулах	Гүний худаг	-	-	-	200,000	2025 онд	
4	задгай асгаснаас үүдэн орчны бохирдол	Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүр гаргуулж, усны төлбөрийг цаг тухай бүрт төлөх	Ус ашиглуулах дүгнэлт	-	-	-	-	2025 онд	
5	үүсэх.	Хаягдал усны дүгнэлтийг гаргуулах	Хаягдал усны дүгнэлт	-	-	-	-	2025 онд	
	Нийт зардал						3,600,000		

6.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Баян ам” нэртэй дайрганы орд нь 2025 онд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй болно.

6.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх газрыг Нийслэлийн байгаль орчны газраас санал авсны үндсэн дээр эвдэрсэн газрыг техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал, шийдвэрт хүрсэн.

Хүснэгт 8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутагтай хамтарч ажиллах, дүйцүүлэн	НБОГ-с санал авсны үндсэн дээр дүйцүүлэн хамгаалах жалыг хийх.	-	-	-	4,000,000	2025 онд	-Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх хэрэгжүүлэх гарын авлага,

	хамгаалах ажил хийх санал орон нутгаас авах, хэрэгжүүлэх.							-БОНБНҮ-ий тухай хууль.
3	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	НБОГ-с санал авсны үндсэн дээр тэрбум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих	-	200	-	2,000,000	2025 онд	
Нийт зардал						6,000,000		

6.4. Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн эдэлбэр газар болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ хийгдэхгүй болно.

6.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвор илрээгүй. Уурхайн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг / 2025 он /	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	-Болзошгүй аюул, осол, аваар гарах.	Ажилд гарахын өмнө ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ажилчдад	-	-	-	Тогтмол	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги,
2	-Галын гэнэтийн аюул үүсэх, -Ажилчид бэртэх, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх.	Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	Ажилчдад	-	-	1,000,000	Жил бүр	
3		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажиллуулах	Уурхайн ажилчид	-	-	2,760,000	Жил бүр	

4	-Уурхайд тэсэлгээний үед аюул үүсэх.	Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, багаж хэрэгслийг байршуулах	Уурхайн кемп орчимд	-	-	2,000,000	2025 онд	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй -MNS 12.4. 005 – 1985: Хөдөлмөр хамгаалал.Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд.
5		Галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах, нөхөж тавих		-	-	500,000	2025 онд	
6		Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүд	-	-	-	Тогтмол	
7		Аваар, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Уурхайн удирдлага	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	
8		Тэсэлгээг мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх.	Тэсэлгээ	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд	
9		Уурхайн тэсэлгээний үед аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах, мэргэжлийн тэсэлгээчнээр гүйцэтгүүлэх.		-	-	-	2025 онд	
Нийт зардал						6,260,000		

6.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /2025 он/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хатуу хог хаягдал	Хог тээвэрлэлтийн гэрээ байгуулж, хог хаягдлыг тухай бүрт тээвэрлүүлэх.	Хог хаягдал	-	-	-	350,000	Жилд 1 удаа	-Хог хаягдлын тухай хууль /2017.05.12/, -MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага,
2		Хог хаягдлын ангиллын зориулалтын хогийн сав байршуулах	Хогийн сав	-	-	-	2,500,000	2025 онд	
3	Аюултай хог хаягдал	Ашигласан шатах, тослох материалыг зориулалтын	ШТМ хадгалах сав, поошик	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	Тухай бүрт	

		саванд хадгалах, уурхайн орчинд асгарч алдагдахаас тухай бүр сэргийлэх, ШТМ дахин боловсруулах үйлдвэр лүү тээвэрлүүлэх	дүүрэхээр тээвэрлүүлэх.						-Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль.
4		ШТМ болон аюултай хог хаягдлыг хадгалах талбайг хатуу хучилттай болгох	ШТМ хадгалах талбай	-	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд	
5		Тэсэлгээний үед хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдлыг тэсэлгээний мэргэжлийн байгууллага хариуцаж, буцаан авч явж устгуулах.	Тэсрэх бодисын сав баглаа боодлын хаягдал	-	-	-	-	2025 онд	
Нийт зардал							2,850,000		

6.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Баян ам” нэртэй дайрганы ордыг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүрт илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэнэ.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх, сөрөг нөлөөллийн эрчим, цар хэмжээ нь зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эсэхийг тогтоох ажиглалт, хэмжилт, дээжлэлт хийх байршил, давтамж, хариуцах этгээд, шинжилгээний арга, шаардагдах зардлыг тооцож тусгана.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг / 2025 он /	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын орчин							
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ хийлгэх	-Ил уурхай орчмоос, -Бутлуурын хэсгээс.	Жилд 1 удаа	Агаарын сорьц дээж 45,000	145,000	Итгэмжлэгдсэн шинжилгээний лаборатори	-MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,

				Агаарын шинжээч – 100,000			-MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, -MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга,
Хөрсөн бүрхэвч							
1	Агрохимийн шинжилгээ: Хөрсний химийн үзүүлэлт (pH, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	-Ил уурхай орчмоос, -Кемп орчмоос.	Жилд 2 удаа	28,000	112,000	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага -MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох.
2	Хөрсний хүнд металлын шинжилгээ: (Cr, Cd, Pb, Ni, Co, Cu)	-Тээвэрлэлтийн замаас.	Жилд 2 удаа	28,000	56,000		
Усан орчин							
1	Усны химийн ерөнхий шинжилгээ: (pH, EC, TDS) нийт шүтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Унд ахуйн уснаас	Жилд 2 удаа	33,000	66,000	Усны итгэмжлэгдсэн лаборатори	-MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага, - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус- химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх, -MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга,
Нийт зардал					379,000		

6.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон Төсөв / 2025 он /	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 онд				
			6-р сар	7-р сар	8-р сар		
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Ажиллагсадыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах	1,840,000		+		Уурхайн удирдлага	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх шаардлагатай.
3	Орон нутагтай нийгмийн хариуцлагын гэрээг шинэчлэн байгуулж, гэрээний дагуу хамтран ажиллах, шинэчлэх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
4	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Дотоод төлөвлөлтөөр	+	+	+	Уурхайн удирдлага	
Нийт зардал		1,840,000					

6.10. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөө

"Амьдралын илч" ХХК нь жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага, нутгийн иргэдэд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт 13. Олон нийтэд тайлагнах, танилцуулах төлөвлөгөө

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд		Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Нийслэлийн байгаль орчны газар	ХБОБНУГ	Тайлан хэлбэрээр, уурхайн талбайд очих.	БОМТ-ийн 2025 оны хэрэгжилтийн тайлан	11-р сарын 01-ны өдрийн дотор	Уурхайд
БОУАӨЯ	БОУАӨЯ-ны ХБОБНУГ	Тайлан			БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т
Төрийн захиргааны төв байгууллага	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Тайлан, төлөвлөгөөг тайлан хэлбэрээр	2026 оны БОМТ	12-р сарын 01-ны өдрийн дотор	-

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

“Амьдралын илч” ХХК-ийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

2025 онд БОМТ-нд нийт **20,379,000** сая.төгрөг зарцуулахаар төлөвлөсөө.

Хүснэгт 14. 2025 оны БОМТ-нд зарцуулах нийт зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, 2025 он /төгрөг/
1	Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3,600,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	6,000,000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,840,000
7	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	6,260,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,300,000
9	Олон нийтэд тайлагнах төлөвлөгөө	-
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	379,000
Нийт дүн		20,379,000

ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Амьдралын илч” ХХК-ийн “Баян ам” нэртэй дайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу биелэлтийн тайланг боловсруулж дараах дүгнэлтэд хүрлээ.

“Амьдралын илч” ХХК-ийн 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайланг БОАЖ-ын Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

Уг төслийн явцад байгаль экологийн унаган төрхийг хамгаалахын тулд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүн, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг мөрдлөг болгон ажиллаж, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу байгаль орчны арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

“Баян ам” нэртэй дайрганы ордын БОМТ-нд 2025 онд нийт **20,379,000** төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

“Амьдралын илч” ХХК нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” БОАЖСайдын А/618 тоот тушаал, 2019 он.
6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014
7. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших 18/М011 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баян ам” дайрганы ордыг ил аргаар ашиглах ТЭЗҮ, 2024 он
8. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Баян ам” нэртэй дайрганы ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2025 он
9. <http://www.legalinfo.mn/>